



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/57

Номгон

“Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчид, ЕБС-ийн хөгжмийн багш нарыг чадваржуулах” сургалтыг зохион байгуулах тухай

Мэргэжлийн соёл, урлагийн байгууллагын уран бүтээлчид, ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарыг мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, Монгол Улсын Засгийн газар 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 314 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дүгээр тогтоолын 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Мэргэжлийн соёл, урлагийн байгууллагын уран бүтээлчид, ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш нарыг чадваржуулах” сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Сургалтыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 6.016.000 (Зургаан сая арван зургаан мянган) төгрөгийг Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг танилцуулан ажиллахыг Соёл, урлагийн газар (Ц.Азбаясгалан)-т, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310139

Аймгийн засаг даргын оны ... дүгээр сарын....
 ны өдрийн 1157 дугаар захирамжийн хавсралт



**МЭРГЭЖЛИЙН УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН УРАН БҮТЭЭЛЧИД,
 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХӨГЖМИЙН
 БАГШ НАРЫГ ЧАДВАРЖУУЛАХ СУРГАЛТЫН ЗАРДАЛ**

№	Материал, бараа бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Сургагч багшийн зардал				
1	Буудал	Хоног	6х*90000₮	540,000₮
			6х80000₮	480,000₮
2	Хоол /Нэг өдрийн хоолны зардал-25000₮/	төгрөг	30.000₮*6өдөр*5багш	900.000₮
3	Багшийн хөлс. /нэг багшийн өдрийн хөлс-120000₮, нийт 5 багш, нэг багш 6 өдрийн сургалтыг зохион байгуулна/	төгрөг	5багш*6өдөр*120.000 өдрийн хөлс	3.600.000₮
4	Унааны зардал	удаа	49.600₮*2/ирж очих/=99.200₮*5багш=496.000₮	496.000₮
Нийт дүн				6.016.000

_____оОо_____